



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/407

Хэрлэн сум

Сургалтад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Дэлхийн мөрөөдлийн сургууль” НҮТББ-аас аймгийн ахлах ангийн сурагчдад зориулан Гадаадад тэтгэлэгтэй суралцахад дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө зорилготой олон улсын менторшип сургалтын зардалд зориулж 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн байгууллага иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ